



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1/272

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хийж гүйцэтгэсэн Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурыг усны шугамд шинээр холбох ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх

- Аймгийн Засаг Даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний  
хяналтын Улсын байцаагч

С.Өнөржаргал

- Газрын харилцаа барилга хот байгуулалтын  
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Цогтхүү

- Стандарт хэмжилзүйн хэлтсийн байцаагч

Ц.Даваасамбуу

- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн архивын тасгийн дарга

М.Нансалмаа

- “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН